



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 16, Засгийн газрын IX байр, Б корпус,
Утас/Факс: (976-51) 26 00 62,

И-мэйл: info@spa.gov.mn, Вэбсайт: www.spa.gov.mn

2020.04.23 № А-1/397
танай _____-ны № _____-т

Тодруулга хүргүүлэх тухай

Тус газраас зарласан ЭШ-4 “Газрын доорх усны хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж, нэгдсэн сүлжээнд холбох ажил” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтад оролцох сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгад дараах хариуг хүргүүлж байна. Үүнд:

Сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулга	Тодруулгын хариу
1.ТООЗ 5.2(в)-д өгөгдсөн хүснэгтэд Ерөнхий инженерийн мэргэжлээрээ ажилласан жил 5 болон түүнээс дээш жил гэж заасан бол ТООЗ 5.3 (г)-д Ерөнхий инженер нь гэрээнд заасан ажилтай төрөл, үнийн дүнгээрээ дүйцэх ажил дээр ажилласан туршлагатай байх хугацаа: Тухайн мэргэжлээр 10 болон түүнээс дээш жил ажилласан туршлагатай байх гэсэн заалтаар зөрсөн. Ерөнхий инженерийн ажилласан жилийн туршлага хэдэн жил байх талаар тодруулж өгөх	ТББ-ийн ТООЗ 5.3 (г)-д Ерөнхий инженер нь гэрээнд заасан ажилтай төрөл, үнийн дүнгээрээ дүйцэх ажил дээр ажилласан туршлагатай байх хугацаа: Тухайн мэргэжлээр 5 болон түүнээс дээш жил ажилласан туршлагатай байх гэж заасан тул ерөнхий инженерийн ажлын туршлага нь тухайн мэргэжлээр 5 болон түүнээс дээш жил байвал шаардлагад нийцсэн гэж үзнэ.
2.Гэрээний тусгай нөхцөлд чанарын баталгаат хугацааг 3 жил гэж заасан бол, Техникийн тодорхойлолтын тавигдах шаардлага хэсэгт баталгаат хугацааг 2 жил гэж тус тус заасан байна. Баталгаат хугацаа хэдэн жил байх талаар тодруулж өгөх	Гэрээний тусгай нөхцөлийг гэрээ байгуулах шатанд захиалагчтай ярилцан тохирч болох тул баталгаат хугацааг техникийн тодорхойлолтод заасны дагуу 2 жил байхаар тогтоож болно.
3.Мэдээллийн технологийн инженер гэсэн мэргэжилд ямар ямар мэргэжлийг хамруулж болох талаар тодруулга өгнө үү.	Мэдээллийн технологи, Программ хангамжийн инженер-Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй мэргэжлээрээ 3-аас дээш жил ажилласан байх шаардлагатай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Х.УЛАМ-ӨРНӨХ

9020020105 СБТ • 11261 6529909

ТХААГ-2020-А4